

байгаа мэдээллийн үнэн зөвийг гаалийн байгууллага нягтлан шалгах ёстой. Үүнд:

-худалдагчийн үнийн жагсаалт;

-статистикийн мэдээлэл, нийтээр хэрэглэх зардлын тариф, комиссын шимтгэл;

-экспортлогчийн үнийн санал, дэлхийн томоохон барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, томоохон импортлогчдын гэрээ, түүний үнэ;

-интернетээр нийтэд зориулан тараасан экспортын үнэ, худалдааны талаархи мэдээлэл;

-хил залгаа улс орны Монгол улсад экспортоор гаргаж байгаа барааны үнийн судалгаа;

-гаальд мэдүүлж байгаа барааны тухайн цаг үед бий болсон үнийн дундаж үзүүлэлт зэрэг болно.

Мэдүүлэгч нь гаалийн байгууллагаас тодорхойлсон гаалийн үнийг хүлээн зөвшөөрөхгүй бол гаалийн тухай хуульд заасны дагуу гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд гомдлоо дараах журмаар гаргана.

Гаалийн Улсын Байцаагчийн шийдвэрт гаргах гомдлыг тухайн гаалийн байгууллагын дарга эрхлэгч



Гаалийн байгууллагын дарга, эрхлэгчийн шийдвэрт гаргах гомдлыг холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтан

Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргана.

Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",
Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 350049
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: http://www.customs.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН ҮНЭЛГЭЭ



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

Импортын барааны гаалийн үнэлгээ

Гаалийн үнэ гэдэг нь гаалийн татвар ногдуулах, гаалийн статистикийн мэдээлэл гаргах зорилгоор тодорхойлж байгаа үнийг ойлгоно.

Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлнэ. Гаалийн мэдүүлэгч өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө. Үүнд:

-гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;

-тээврийн бичиг баримт;

-тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;

-хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт;

-Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг.

МЭДҮҮЛЭХ:

МЭДҮҮЛЭГЧ:

- Бичиг баримтыг үндэслэн мэдүүлнэ.
- Дурын, эсхүл зохиомол үнэ хэрэглэхийг хориглоно.
- Бичиг баримтыг гаргаж өгнө.

ШАЛГАХ:

ГААЛЬ:

- Үнийг зөв, бодитой тодорхойлсон эсэхийг шалгана.
- Шийдвэр гаргана.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу импортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо дараах аргуудыг дэс дарааллын дагуу хэрэглэнэ.

- 1.Хэлцлийн үнийн арга;
- 2.Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга;
- 3.Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга;
- 4.Ялгавар үнийн арга;
- 5.Нийлбэр үнийн арга;
- 6.Уялдуулан хэрэглэх арга.

Хэлцлийн үнийн арга. Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох үндсэн арга нь хэлцлийн үнийн арга юм. Хэлцлийн үнэ гэдэг нь худалдагч, худалдан авагч талуудын хооронд байгуулсан гэрээ, хэлцлийн үр дүнд тохирсон гадаад худалдааны үнэ бөгөөд гаалийн үнийг тодорхойлох анхдагч суурь болдог.

Мэдүүлэгч нь тухайн барааны хэлцлийн үнэ дээр үндэслэн холбогдох зардлуудыг нэмж тооцон хэлцлийн үнийн аргаар барааны гаалийн үнийг мэдүүлдэг. /схем 1/

$$ГҮ=ХҮ+(Т+К+Д+П+О)-Х$$

-ГҮ- гаалийн үнэ

-ХҮ -хэлцлийн үнэ

-(Т+К+Д+П+О) –тээврийн зардал, комиссын шимтгэл, дэмжлэг, оюуны өмч, орлого нэмэгдэх бүлэг зардал

-Х -хасагдах бүлэг зардал

Гаалийн байгууллага дараах тохиолдолд гаалийн үнийг мэдүүлэгчийн тодорхойлсноос өөр аргаар тодорхойлно.

-Гаалийн үнийг тодорхойлоход ашигласан бичиг баримт баталгаажуулаагүй, эсхүл түүнд тусгагдсан мэдээлэл зөрсөн, бүрэн бус, тоон үзүүлэлт нь хангалтгүй байсан бол,

-Мэдүүлэгч нь гаалийн үнийн үнэн зөвийг нотолж чадаагүй бөгөөд гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон үнийг үндэслэлгүй гэж үзсэн бол.

Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга

Импортын барааны гаалийн үнийг хэлцлийн үнийн аргаар тодорхойлох боломжгүй бол гаалийн үнийг нь тодорхойлж буй бараатай ойролцоо хугацаанд импортлосон нэг төрлийн барааны хэлцлийн үнэд үндэслэн тухайн барааг үнэлдэг.Нэг бараа нөгөө бараатай нэг төрлийн бараа мөн эсэхийг тогтоохдоо дараах шалгуур шинжийг ашиглана. Үүнд:

-барааны гарал үүслийн улс;

-үйлдвэрлэгч;

-чанар, барааны тэмдэг болон барааны нэр хүнд;

-физик шинж

Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэх үндсэн зарчим нь гаалийн үнийг нь тодорхойлж буй бараатай тухайн цаг үед буюу ойролцоо хугацаанд, ойролцоо тоо хэмжээнд, худалдааны ижил түвшинд импортлосон барааны хэлцлийн үнийг үндэслэнэ.

Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга

Ижил төрлийн бараа гэдэгт үнийг нь тодорхойлж байгаа бараатай бүх талаараа адил биш боловч үндсэн шинж байдал, бүрдэл хэсэг, зориулалтаараа ижил, арилжааны талаас харилцан бие биенээ орлож чадах барааг ойлгоно. Нэг бараа нөгөө бараатай ижил төрлийн бараа мөн эсэхийг тогтоохдоо дараах шалгуур шинжийг ашиглана. Үүнд:

-барааны гарал үүслийн улс;

-чанар, барааны тэмдэг болон барааны нэр хүнд;

Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэх үндсэн зарчим нь гаалийн үнийг нь тодорхойлж буй бараатай нэгэн зэрэг буюу ойролцоо хугацаанд, ойролцоо тоо хэмжээнд, худалдааны ижил түвшинд импортлосон ижил төрлийн барааны хэлцлийн үнийг үндэслэнэ.

Уялдуулан хэрэглэх арга

Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох хамгийн сүүлчийн арга нь уялдуулан хэрэглэх арга бөгөөд өмнөх 5 аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд энэ аргаар тухайн барааны гаалийн үнийг тодорхойлдог. Уялдуулан хэрэглэх аргаар импортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо дараах хоёр арга замаар хэрэгжүүлдэг.

Нэгдүгээр арга зам: Гаалийн үнэлгээний эхний 5 аргад заасан шаардлага, нөхцөлүүдийг багасгах, бууруулах, зөөлрүүлэх байдлаар хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл өмнө тогтоосон гаалийн үнэ дээр үндэслэн тухайн барааны гаалийн үнийг тодорхойлно.

Хоёрдугаар арга зам: Олон улсын худалдааны практик болон тухайн үеийн арилжааны бусад мэдээлэл дээр тулгуурлан тогтооно. Энэ арга замаар гаалийн үнийг тогтоохдоо импортын оронд байгаа мэдээ, мэдээлэл баримтыг ашиглана. Импортын оронд